



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/06-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2024 он	Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Б.Азантунгалаг Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139, Утас/Факс: (976) 7033 3141, Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn	"ХАЙРХАН ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ А.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА
2024.03.15 № 152 танай -ны № -т	
Хязгаарлалттай дүгнэлт	
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн тул хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд: 1. Дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг батлуулаагүй дулаан эрчим хүч борлуулан 289,171.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь Эрчим хүчний тухай хуулийн 13.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. 2. "Хөгжлийн түүчээ хайрхан" хоршооноос 31,207.2 мянган төгрөг, "Хоёр өжөө" ХХК-аас 181.8 мянган төгрөг, Аж ахуй нэгж байгууллагаас авах дулааны төлбөр 1,906.8 мянга нийт 33,295.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	

3. 2023 оны 54,196 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

"Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан байна.

Аудитын онцолсон асуудал

Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ нь Архангай аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 09 сарын 20-ны өдрийн 11/2023 дугаартай дулаан түгээх тусгай зөвшөөрөл авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 онд Зорилтот түвшин эдийн засгийн үзүүлэлтээр 320,440.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр бизнес төлөвлөгөөг батлан 305,471.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.3 хувиар биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		1-р сарын 01	12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	310,100.00	763,177.41
1.1.2	Дансны авлага	-	33,295,789.46
1.1.3	Татвар, НДШ авлага	-	494,000.00
1.1.4	Бусад авлага	1,000.00	
1.1.6	Бараа материал	18,551,800.00	15,170,059.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,862,900.00	49,723,026.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	27,168,100.00	87,560,081.58
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,168,100.00	87,560,081.58
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	46,031,000.00	137,283,108.04
2.1.1.1	Дансны өглөг	8,000,000.00	42,998,773.00
2.1.1.3	Татварын өр	401,700.00	11,197,236.06
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөр	8,401,700.00	54,196,009.06
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,401,700.00	54,196,009.06
2.3	Эздийн өмч		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	37,629,300.00	83,087,098.98
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	37,629,300.00	83,087,098.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН	46,031,000.00	137,283,108.04

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого (Цэвэр орлого)	130,627,800.00	305,471,470.49
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	40,636,800.00	133,354,441.92
3. Нийт ашиг (алдагдал)	89,991,000.00	172,117,028.57
10. Ерөнхий ба удирдлагын зардал	51,981,600.00	121,608,363.01
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	38,009,400.00	50,508,665.56
19. Орлогын татварын зардал	380,100.00	5,050,866.55
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	37,629,300.00	45,457,799.01
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	-	-	37,629,300.00	37,629,300.00
3	Залруулсан үлдэгдэл	-	-		
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	45,457,789.98	45,457,789.98
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-		
7	Зарласан ногдол ашиг	-	-		
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн	-	-		
9	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	-	-	83,087,098.98	83,087,098.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	137,627,800.00	318,664,702.84
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	130,627,800.00	318,664,702.84
Бусад мөнгөн орлого	7,000,000.00	-
1.2 Мөнгөн зарлагын дүн	110,967,900.00	273,722,725.43
Ажиллагчдад төлсөн	26,899,800.00	81,739,970.50
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,821,300.00	25,682,224.56
Бараа материал худалдан авахад төлсөн	11,121,100.00	84,216,061.52
Ашиглалтын зардал төлсөн	7,374,200.00	24,992,344.69
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	48,100,900.00	13,587,630.00
Татварын байгууллагад төлсөн	1,916,200.00	10,209,704.70
Бусад мөнгөн зарлага	7,734,400.00	33,294,789.46
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,659,900.00	44,941,977.41
2. Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
2.2 Мөнгөн зарлагын дүн	19,349,800.00	44,488,900.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,349,800.00	44,488,900.00
2.3 Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(19,349,800.00)	(44,488,900.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	7,000,000.00	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	7,000,000.00	-
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(19,349,800.00)	(44,488,900.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	310,100.00	453,077.41
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		310,100.00
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	310,100.00	763,177.41

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

ДД	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Ус борлуулсны орлого	9,600,000.00	10,783,828.00	(1,183,828.00)	112.3%
2	Дулааны борлуулалтын орлого	297,280,272.00	289,171,574.84	8,108,697.16	97.2%
3	Хогны хураамжийн орлого	13,560,000.00	18,480,000.00	(4,920,000.00)	136.28%
4	Түрээсийн орлого	-	230,000	(230,000.00)	
Нийт орлогын дүн		320,440,272.00	305,471,470.49	14,968,801.51	95.3%
1	Үндсэн ба нэмэгдэл цалин, НДШ	115,387,250	115,008,135.66	379,114.34	99.6%
2	Цахилгаан өөрийн хэрэглээ	25,000,000	24,992,344.69	7,655.31	99.9%
3	Түлш, шатахуун, тээврийн зардал	105,500,000	107,085,255.00	(1,585,255.00)	101.5%
4	Засвар, үйлчилгээний зардал	13,000,000	3,723,806.68	9,276,193.32	28.6%
5	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	650,000		650,000.00	0.00%
6	Конторын хангамжийн зардал	703,000	13,511,687.00	(12,808,687.00)	1922.0%
7	Хөдөлмөр хамгааллын зардал	1,602,201	1,453,446.16	148,754.84	90.7%
8	Бусад төлбөр хураамж	1,000,000	1,000,000.00	-	100%
9	Өмч худалдан авах зардал	47,333,821	44,488,900.00	2,844,921.00	93.9%
10	Ажиллагсдын нийгмийн зардал	6,892,000	6,892,000.00	-	100%
Нийт зарлагын дүн		317,068,272	260,013,671.48		100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа ¹ илрээгүй. Залруулагдаагүй 376,663.4 мянган төгрөгийн зөрчил ² илэрснээс 322,467.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой асуудалд 54,196.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

5.2.1. Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ нь Архангай аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 09 сарын 20-ны өдрийн 11/2023 дугаартай дулаан түгээх тусгай зөвшөөрөл авсан байна. Дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй "Галт зүрх" ХХК-ны хуучин тарифаар үйл ажиллагаа явуулж 289,171.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан худалдах үнэ, нөхцөлийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор хянуулж батлуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг батлуулах албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 "Хөгжлийн түүхээ хайрхан" хоршооноос 31,207.2 мянган төгрөгийн, "Хоёр өжөө" ХХК-аас 181.8 мянган төгрөг, харилцагч байгууллагаас авах 1,906.8 мянга, нийт 33,295.8 авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой.

Илрүүлэлт: / Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2."Аж ахуйн нэгж, байгууллагын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлан мөрдөж ажиллах арга хэмжээ авах

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: / Тайлант хугацаанд дансны өглөг 46,196.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 54,196.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах.*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг анхаарна уу.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

[illegible]

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дулаан эрчим хүчний тарифгүй	1	289.171.6			1	289,171.6						
Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	33,295.8			1	33,295.8						
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	54,196.0					1	54,196.0				
НБББББ-гүй	1	-					1	-				
Нийт дүн	4	376,663.4			2	322,470.4	2	54,196.0				

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй								

